

“МОНГОЛ, АНУ-ЫН ХАРИЛЦААНЫ ТӨЛӨВ: СТРАТЕГИЙН ТҮНШЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ”

*Дипломат Академийн захирал,
Элчин сайд Х.Бэхбат*

Миний илтгэлийн сэдвийг ийнхүү томъёолсон байдлаас үүдээд би Монгол Улс-АНУ-ын харилцаа, хамтын ажиллагааг түүхчилж хүүрнэх гэхээсээ илүү өнгөрсөн, өнөөдрийн туршлага, бодит байдал нь тулгуурлан цаашдын хөгжлийн төлөв, шаардлагыг товойлгож харахад голлон анхааръя гэж бодож бэлтгэлээ.

Эдүгээ бид Монгол-америкийн харилцааг “иж бүрэн түншлэл” хэмээн тодорхойлж байгаа. Тухайлбал, 2005 онд дээд хэмжээнд гаргасан хамтарсан мэдэгдэлд хоёр талын хамтын ажиллагааг “хамтын үнэт зүйлс, стратегийн нийтлэг ашиг сонирхолд тулгуурласан иж бүрэн түншлэл” хэмээн томъёолсон байдаг билээ. Хэрэвзээ энэ харилцаа, хамтын ажиллагаа анхнаасаа цуцалтгүй урагшлан ахиж, амжилттай хөгжиж ирлээ гэж үзэх ахул, дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойгоо тэмдэглэж буй энэ түүхэн чухал зааг дээр дараачийн үе шатны тухай, “стратегийн түншлэлийн “ түвшинд хөгжүүлэх талаар сэтгэн бодож, оролдох нь зүй ёсны хэрэг гэж үзүүштэй. Нэгэнт “стратегийн түншлэл” гэж ярих учраас юуны өмнө энэ ойлголтоо нэг мөр болгохоос эхэлье.

Эрдэмтэн мэргэдийн үзэж байгаагаар бол латинаар “strategia” гэх энэ үгийг эртний грекүүд цэрэг дайны урлагт хэрэглэж эхэлсэн бөгөөд хожим улс төрийн салбарт өргөнөөр хэрэглэгдэх болж

“ухаалаг удирдлага”, “удирдахуйн ухаан” гэж ойлгодог, чингэхдээ урт удаан хугацаагаар, ирээдүйг төсөөлөх, үйл явдлыг урьдчилан харах үндсэн дээр үйлдлээ төлөвлөхийг багтаан хэлдэг байна. Бизнес, аж ахуйн харилцаанд голдуу хэрэглэдэг “түншлэл” гэдэг нэр томъёог улс хоорондын харилцаанд хэрэглэх болоод төдий л удаагүй боловч ерөнхийдөө “аливаа тодорхой зорилгоор харилцан хариуцлага хүлээж, хамтран ажиллахыг” түншлэлийн харилцаа гэж тодорхойлж тогтоод байгаа. Өөрөөр хэлбэл түншлэлийн харилцаа нь харилцан ашигтай байхын зэрэгцээ аль аль түнш нь асуудал шийдвэрлэхдээ нөгөөхийнхөө ашиг сонирхолыг харгалзаж, уялдуулж байх хариуцлага хүлээнэ гэж ойлгодог ажээ.

Энэ хоёр ойлголтыг хослуулснаар “с/т” гэдэг нь: 1/урт удаан хугацаагаар, 2/өргөн хүрээтэй асуудлаар, 3/аль аль талдаа аль болохоор ашигтайгаар хамтран ажиллахыг хэлдэг байна. Францын нэгэн судлаачийн бичсэнээр бол “талууд ойр, нягт хамтран ажиллах зорилгоор явуулж буй харилцааны систем” ч гэж товчхон тодорхойлж болно.

Цаашилбал, Оросын эрдэмтэн судлаач И.А.Новиковын үзэж байгаагаар ”с/т”- д норматив буюу хэм хэмжээ тогтоох үүднээс хандвал дараахь шалгуур үзүүлэлтүүд буюу зарчмын шаардлага байж болох аж. Үүнд:

- Түншүүд хамтран ажиллах сонирхолтой байх,
- Хүч чармайлтаа нэгтгэн зохицуулж байж л хэрэгжүүлж болох стратегийн чухал зорилгуудтай байх,
- Түншүүдийн улс төрийн системийн үнэт зүйлсүүд адилхан байх,
- Хамтын ажиллагааны талбар өргөн, салбар олон байх,
- Х/а-ны агуулга, түүнийг хэрэгжүүлэх механизмыг тодорхойлсон эрх зүйн үндэс бүрэлдсэн байх,
- С/т хэрэгжүүлэх механизм нь хэвшин тогтсон байх,
- Харилцаа нь удаан хугацааны шинж чанартай байх,
- Бие биенээ хүндэтгэж, харилцан дэмжиж,эрх ашгаа харилцан харгалздаг байх,
- Түншлэлийн үр ашгийг нийгэм бүхэлдээ хүртэх,- зэрэг болно.

С/т-н шалгуур үзүүлэлтүүд нь дээр сая дурдсанаар зөвхөн хязгаарлагдахгүй боловч түүний агуулга, хүрээ контурыг бүхэлд нь тодорхойлж чадаж байна гэж дүгнэж болно. Чингэх ахул М-АНУ-гийн харилцааг эдгээр шалгууруудын үндсэн дээр дараахь маягаар, үндсэн гурван бүлэгт хуваан үзэж болох юм. Үүнд:

Нэг. Хоёр улс, ард түмний хооронд хэлхээ холбоо тогтоож хөгжүүлэх сонирхол бүр 19 дүгээр зууны эцэс, 20 дугаар зууны эхнээс тодорч цаг үеийн хувьслын аясаар өөрчлөгдөж ирсэн байдаг. Харилцаа тогтоох тухай Богд хаант засгийн захидал, Сокобин, Рокхиллийн үйл ажиллагаа, “американ дэнж”, “Монголор”, Эндрюсийн экспедици, хоёр Рузвельтын хандлага, дэд ерөнхийлөгч Уоллесийн айлчлал, гадаад Монголын “статус-кво”-г зөвшөөрүүлж, НҮБ-д элссэн, “Мистер нет”-тэй тулгарсан зэргээр 20 дугаар зууны Монголын түүхийн бүхий л нугачааг даван туулж, чингэхдээ үргэлж бэхжсээр иржээ. 30 жилийн өмнө хоёр улсын хооронд албан ёсны харилцаа тогтоосноор энэ сонирхол бодитойгоор хэрэгжих өргөн ирээдүй нээгдсэн бөгөөд эдүгээ, хэдийгээр өөр өөр түвшний боловч нийтлэг гео-улс төр, эдийн засгийн болоод оюун санааны сонирхол болон төлжиж монгол-америкийн харилцаа, хамтын ажиллагааны амин сүнс нь болж байна. /энэхүү нийтлэг буюу харилцан сонирхол нь бүхэлдээ Монголын үндэсний эрх ашигт нийцэж, АНУ-ын “зуун дамнасан глобал лидерийн байр суурь, бодлого, үйл ажиллагаанд суурилж буй гэж хэлж болно/.

1990 оноос Монгол улс ардчилсан хөгжлийн замд шилжиж манай хоёр улс, ард түмний нийгэм-улс төрийн үнэт зүйлс ижилссэнээр харилцаа, хамтын ажиллагаа цаашид тогтвортой, удаан хугацаагаар өргөжин хөгжих бат бэх үндэс бүрэлдсэн юм. Энэхүү ижилсэл, өөрөөр хэлбэл ардчилал, хүний эрх, эрх чөлөө, чөлөөт зах зээл зэрэг ойлголт монголын нийгмийн ухамсар, ухамсарт үйлдлийн тодорхойлогч хэмжигдэхүүнүүд болж энэ ч үндсэн дээр монгол-америкийн харилцааны /түүхэн тодорхой үеийн/ стратегийн үндсэн зорилгуудыг хоёр тал бүр ерээд оны эхнээс адилханаар томъёолж ойлгож ирсэн байдаг. Үүнд: 1-д Монголын шинэ, тулгар ардчилсан тогтолцоог бэхжүүлэх, 2-т шилжилтийн үеийн бэрхшээлийг давж чөлөөт зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэх, 3-т дэлхий нийтийн болон бүс

нутгийн улс төрийн бодлого, эдийн засгийн интеграцид Монголыг нэгтгэх явдал байв. Үүнийг хоёр талын төр, засгийн төлөөлөгчдийн мэдэгдэл, албан баримт бичгүүд, түүний дотор АНУ-ын Конгрессийн удаа дараагийн тогтоол, тухайлбал 1998 оны Сенат, Төлөөлөгчдийн танхимын хамтарсан 60 дугаар тогтоол болон мөн оны 7 дугаар сард гаргасан МУИХ-ын 87 дугаар тогтоолоос тодорхой харж болно. Эдгээр стратегийн хамтын зорилгууд өнөөдөр ч ерөнхийдөө хэвээр байгааг Монголын ардчиллын 25 жилийн ойг тохиолдуулан АНУ-ын хууль тогтоогч дээд байгууллагаас гаргасан тогтоол мөн харуулж байна

Хоёр. Өнгөрсөн 3 арван жилийн явцад хоёр талын харилцааг зохицуулагч эрх зүйн үндэс эрчимтэй бүрэлдэж ирлээ. Үүнд МУ-ын ҮАБ,ГБ-ын үзэл баримтлалууд, хоёр улсын хууль тогтоох дээд байгууллагуудаас удаа дараа гаргаж ирсэн тогтоолууд, засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрүүд, хоёр талын төрийн яам, агентлаг хоорондын санамж бичгүүдээс авахуулаад ТББ-ууд, муж,хот , орон нутгийн бусад байгууллага хоорондын тохиролцоо, аж ахуйн нэгж хоорондын гэрээ контракт хүртэл өргөн хүрээтэй нэг талын болон хамтарсан акт, баримт бичгүүд багтаж байна. Эдгээр баримт бичгүүдийн эрх зүйн чадавхи харилцан адилгүй боловч хамтын ажиллагааны үндсийг тэтгэгч нэгэн систем бий болоод байна гэж үзэж болно. /Хоёр талаас харилцан солилцсон дээд, өндөр хэмжээний айлчлалын төгсгөлийн баримт бичиг 6 , МУИХ, АНУ-ын Конгрессийн тогтоол 10 орчим байгаа нь хамтын ажиллагааны улс төрийн үндсийг тодорхойлж, засгийн газар хоорондын болоод яам хоорондын 30-аад гэрээ хэлэлцээр байгуулсан нь тодорхой салбар, асуудлуудаарх практик харилцааны хөгжлийн үндсийг бүрэлдүүлж байна/.

Энэ бүх баримт бичгүүд дотроос 2007 оны 10 дугаар сард Вашингтон хотноо үсэг зурсан “Монгол улс, Америкийн Нэгдсэн Улсын ойр дотно хамтын ажиллагааны зарчмуудын тухай тунхаглалыг” онцгойлон жишээ болгон авч үзэж болох юм. Уг баримт бичигт нэгдүгээрт, иж бүрэн түншлэлийн “удирдлага болгох зарчмуудыг тодорхойлж”, хоёрдугаарт, “хүрээг нь өргөтгөсөн” байдаг. “Зарчим” гэдгийг бид харилцаандаа баримтлах, удирдлага болгох үзэл, чиглэл, цогц ойлголт гэдэг өргөн утгаар авч үзэх учиртай бөгөөд үүнд нийт 8

зарчмыг тодорхойлжээ. Үүнд:

- Ардчиллын үнэт зүйлсүүдэд үнэнч байх, худалдаа, хөрөнгө оруулалтын саад бэрхшээлийг арилгаж, хөгжүүлэн бэхжүүлэх, хоёр болоод олон талт аюулгүй, тогтвортой байдлын төлөө үйл ажиллагаанд оролцох, иргэд хоорондын харилцаа, солилцоог хөнгөвчлөн хөгжүүлэх, дэлхий нийтийн шинж чанартай аюул заналын эсрэг бүхий л түвшинд бусад улс орнуудтай хамтран ажиллах, эрүүл, байгаль орчинд ээлтэй хөгжлийн төлөө төр засаг, иргэний нийгэм, хувийн хэвшлийн түншлэлийг улс орны хэмжээнд хөгжүүлэх, хоёр орон болон бүс нутгийн сайн сайхан, энх тайвны төлөө нэгдмэл ашиг сонирхолд тулгуурласан эрх тэгш, иж бүрэн түншлэлийг хөгжүүлэх, харилцан сонирхсон асуудлуудаар хоёр засгийн газар бүхий л түвшинд тогтмол санал солилцож байх.,-гэжээ. Улмаар хамтын ажиллагааны тодорхой салбаруудыг нэрлэсэн байдаг. Үүнд: улс төр, эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалт, боловсрол, соёл, урлаг, шинжлэх ухаан, технологи, ххүрээлэн буй орчин, эрүүл мэнд, батлан хамгаалах, аюулгүй байдал, хүмүүнлэгийн болон бусад салбарт урт удаан хугацаагаар хамтран ажиллах эрмэлзэл төгс байгаагаа хоёр тал дахин нотолж тунхагласан байна.

Өнгөрсөн хугацаанд бүрэлдэн хэвшсэн яриа хэлцээний механизмын хувьд үндсэндээ дараахь 3 төрөлд хуваан үзэж болно. Юуны өмнө өндөр, дээд хэмжээний харилцан айлчлал ихээхэн идэвхтэй, тогтмол явагдаж ирсэнийг тэмдэглэе. 1990 оноос хойш манай талаас төрийн тэргүүн 4 удаа, Их хурлын дарга 3 удаа, ерөнхий сайд 8 удаа, ГХ-ны сайд 6 удаа, БХ-ын сайд 3 удаа тус тус АНУ-д айлчилж, айлын талаас ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч тус тус нэг удаа, гадаад хэргийн сайд нь 5 удаа, спикер 1 удаа, БХ-ын сайд нь 2 удаа тус тус айлчилжээ. Өөрөөр хэлбэл, дээд, өндөр түвшний 1-2 уулзалт жил тутам тогтмол болж ирсэн нь хоёр талаас харилцаа, хамтын ажиллагаанд өгч буй анхаарал, ач холбогдлыг тодорхой харуулж байна. Хоёрт, ГХ-ийн яам хоорондын улс төрийн зөвлөлдөх уулзалт 1-2 жил тутам тогтмол болж харилцаа, хамтын ажиллагааг цогцоор авч хэлэлцэж ирлээ. Хамгийн сүүлчийн уулзалт өнгөрсөн оны 11 дүгээр сард Вашингтон хотноо болж өнгөрөв. Түүнчлэн Батлан

хамгаалах яам хоорондын дээд, дунд хэмжээний Зөвлөлдөх уулзалтыг жил бүр зохион байгуулж байгааг тэмдэглэх нь зүйтэй юм. Гуравт, Худалдаа, хөрөнгө оруулалтын ерөнхий хэлэлцээрийн (ТИФА 2004.07) дагуу байгуулагдсан Монгол, АНУ-ын Худалдаа, хөрөнгө оруулалтын зөвлөл нь худалдаа, хөрөнгө оруулалт болон тарифын бус саад тотгор, оюуны өмчийн эрх, хөдөлмөр, байгаль орчин, ил тод байдал зэрэг өргөн хүрээтэй асуудлаар зөвлөлдөх механизмын үүрэг гүйцэтгэдэг. Уг зөвлөл жилд нэгээс доошгүй удаа хуралдаж байх ёстой боловч 2005-2008 онуудад хуралдаад, “Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай хэлэлцээр” байгуулах явцтай уялдан тасалдаж 2015 оноос дахин сэргэсэн болно.

Дээр дурдсанаас үзвэл, хоёр талын харилцааг зохицуулагч эрх зүйн үндсийн зэрэгцээ түүнийг тээж хэрэгжүүлэгч механизм нь бүрэлдэн тогтоод байна. Харин энэ механизмаа цаашид тогтмолжуулах, үр нөлөөг нь дээшлүүлэх талаар анхаарч байх шаардлага хэвээр байна.

Гурав. Монгол, АНУ-ын түншлэлийн өнөөгийн байдлыг илтгэсэн зарим тоо баримтыг дурдая.

Юуны өмнө манай шилжилтийн үеийн хүндрэлийг даван туулж, хувийн секторт тулгуурласан эдийн засгийн шинэ тогтолцоог бүтээн босгоход олон улсын тусламж дэмжлэгийг дайчлан чиглүүлэхэд АНУ шийдвэрлэх үүрэг гүйцэтгэснийг тэмдэглэх нь зүйтэй юм. Үүний хамт хоёр талын шугамаар 1991 оноос хойш олон зуун сая доллараар хэмжигдэх санхүү-техник, эд материалын тусламж үзүүлж ирлээ. АНУ-ын албан ёсны тусламж нь Олон улсын хөгжлийн агентлаг, Батлан хамгаалах яам, Хөдөө аж ахуйн яам гэсэн 3 байгууллагын шугамаар ихэвчлэн хэрэгжиж ирсэн. Зөвхөн Олон улсын хөгжлийн агентлаг (USAID) 1991 оноос хойш нийт 240 орчим сая долларын буцалтгүй тусламж үзүүлээд байна. 2008 оноос Мянганы сорилтын сангийн шугамаар 285 сая долларын буцалтгүй тусламж / эрүүл мэнд, мэргэжлийн боловсрол, хот орчмын бэлчээрийн менежмент, хөрөнгийн эрх, авто зам, цэвэр агаар гэсэн 6 төсөл/ амжилттай хэрэгжиж, 2013 оны 9 дүгээр сард дуусгавар болсон. Эдүгээ хоёрдахь компакт гэрээг байгуулахаар хоёр тал ажиллаж байна.

1990 оноос хойш манай улсад АНУ-ын дагнасан болон хамтарсан хөрөнгө оруулалттай 310 гаруй компаний нийт 308 сая орчим ам.долларын хөрөнгө шууд орсон байх бөгөөд Монголд хөрөнгө оруулсан орнуудын жагсаалтад 9-рт эрэмлэгдэж байна. Манай улс АНУ-тай 2015 онд 135.2 сая долларын худалдаа хийсэн нь манай нийт гадаад худалдааны дөнгөж 1.6 хувийг эзэлжээ. Хоёр талын худалдааны эргэлт тэнцвэргүйн дээр ихээхэн тогтворгүй байна. Худалдаа-эдийн засгийн харилцааны асуудлаар тусгайлсан илтгэл бий. Миний бие өөрийн зүгээс энд ганц л зүйлийг тэмдэглэмээр байна. Монгол-америкийн иж бүрэн түншлэлийн хамгийн сул цэг нь чухамхүү худалдаа-эдийн засгийн салбарт байна. Хоёр талын харилцааны бодит үндэс, америкийн бодит сонирхлыг буй болгох талаар олон жилийн өмнөөс тунхаглаж ирсэнээ хэрэгжүүлэх, энэ үүднээс бодлогоор тууштай дэмжиж ажиллах цаг иржээ гэж би судлаачийн хувьд харж байна.

Хоёр талын боловсрол, соёл, шинжлэх ухаан-технологийн болон хүмүүнлэгийн зэрэг салбарын солилцоо байнга өсөн нэмэгдэх чиглэлээр хөгжиж байна. АНУ-ын олон улсын оюутны статистик мэдээлэлд дурдсанаар 2014-2015 оны хичээлийн жилд нийт 1481 монгол оюутан АНУ-д суралцаж байв. /энэ тоо 1999-2000 онд 43, 2003-4 онд 374, 2010-11 онд 1238 байжээ/ АНУ-ын “Энх тайвны корпус” 1991 оноос хойш нийт 1200 гаруй сайн дурын ажилтнаа манай улсад илгээж, боловсрол, эрүүл мэнд, байгаль орчин, жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулж ирэв. /2015 оны санхүүгийн жилд нийт 3 орчим сая ам.долларын төсөвтэй, 125 сайн дурын ажилтантай үйл ажиллагаа явуулсан байна. Жилд дунджаар 130 орчим сайн дурын ажилтан манай улсад ажилладаг./

1998-2014 онд нийт 116,805 монгол иргэн төрөл бүрийн визээр АНУ-д зорчсон тоо байдаг. АНУ-ын 200 орчим хотод нийт 25 мянга гаруй монгол иргэн ажиллаж, амьдарч, сурч байна. 2003-2014 онд нийт 7050 монгол иргэн АНУ-д байнга оршин суух зөвшөөрөл¹ авснаас 1825 нь АНУ-ын иргэншил авчээ.

1 The Yearbook of Immigration Statistics 2014, U.S. Department of Homeland Security

Дээр бүх өгүүлснээс үзвэл өнөөдөр монгол-америкийн харилцаа манай гадаад бодлогын нэгэн чухал бодит хүчин зүйл болж, монголын нийгмийн гадаад харилцааны системд өөрийн тодорхой орон зайг эзлэн хөгжиж байна. Улс төр, аюулгүй байдлын салбарын хамтын ажиллагаа нь Монгол Улсын олон улсын байр суурь, үүрэг ролийг өсгөн бэхжүүлэхэд нааштайгаар үйлчилж байна. АНУ-ын нөлөө, түүний тусламж дэмжлэг, манай харилцан ажиллагааны үр нөлөө нийгмийн оюун санааны болон бодит давхрага, салаа мөчрүүдэд байнга илэрч байдаг болжээ.

АНУ бол манай чухал нэгэн “гуравдагч хөрш” бөгөөд монгол-америкийн харилцаа нь дээр тодорхойлсон хэв хэмжээ, урьдчилсан нөхцлийг хангахуйц хэмжээнд хүрч хөгжиж байна гэж үзүүштэй. Үүнийг цаашид баталгаажуулах, юуны өмнө худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэн гүнзгийрүүлэх замаар “стратегийн түншлэлийн” түвшинд хөгжүүлэх шинэ үе шат эдүгээ нээгдэж байна.

* * *

Элчин сайд Х.Бэхбатын товч намтар:

Монголын дипломатын Академийн захирал, Олон улсын харилцаа, түүхчийн мэргэжилтэй, Боловсролын доктор /PhD/.

Москвагийн Олон улсын харилцааны дээд сургууль, Нийгмийн ухааны академийн аспирантурт тус тус суралцсан.

Ажлын туршлага:

- 1973-1976 ГЯЯ-нд дэд атташе.
- 1976-1981 Парис дахь ЭСЯ-нд атташе.
- 1981-1985 ГЯЯ-нд 3-р нбд, хэлтсийн дарга.
- 1985-1987 МАХН-ын ГХ-ны ГХХ-ийн орлогч эрхлэгч.
- 1990-1991 Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх.
- 1991-1992 ГХ-ны дэд сайд, ЮНЕСКО-ийн МҮК-ын дарга.
- 1993-1998 Монгол Улсаас Франц / Итали, Испани, Португали/
Улсад суугаа Элчин сайд, ЮНЕСКО-ийн дэргэдэх Байнгын төлөөлөгч.
- 1998-2000 ГХЯ-ны Улс төрийн газрын дарга.
- 2000-2001 Тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайд.
- 2001-2005 Монгол Улсаас НҮБ-ын Женев /Вена, Ром/ дэх салбар болон олон улсын бусад байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч, Швейцарь, Лихтенштейнд суугаа Элчин сайд
- 2006-2008 ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга
- 2008-2012 АНУ-д суугаа Элчин сайд
- 2013-2015 ТҮГЭС, Дипломатын академийн захирал
- 2016- МДА-ийн захирал, МУИС-ийн ОУХНУС-ийн зочин проф.